



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 983

Улаанбаатар хот


Үндэсний Татварын албаны Хүний нөөцийн бодлого батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний татварын албаны "Хүний нөөцийн бодлого"-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. "Хүний нөөцийн бодлого"-ыг байгууллагын хөгжлийн зорилтот хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тухайн үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгон ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар /С.Орхон/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Т.БАТМАГНАЙ



ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Нэг. Зорилго

- 1.1. Үндэсний татварын албаны хүний нөөцийн бодлого нь Монгол Улсын хууль, тогтоомж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, байгууллагын хөгжлийн зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хугацаанд нь чанартай, бүрэн хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
- 1.2. Үндэсний татварын албанаас хүний нөөцийн талаар баримтлах нэгдсэн бодлого нь татварын албаны хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, судлах, төлөвлөх, албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх замаар тэдний чадавхыг дээшлүүлэх, сэлгэн ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн албаны залгамж шинжийг хадгалахад оршино.

Хоёр. Үндэсний татварын албаны хүний нөөцийн бүрэлдэхүүн

Үндэсний татварын албаны хүний нөөцийн бодлогыг олон нийтэд нээлттэй болгож, хариуцлага, хяналтыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон мөрдүүлж, хүнд сурталгуй, авилгаас ангид төрийн үйлчилгээг бий болгох, хууль дээдлэн, зохих шаардлагыг хангасан хөдөлмөрийн насны хүн бүрийг эрх тэгш, татварын албананд ажил хөдөлмөр эрхлэх боломж бололцоогоор хангах бодлогын хүрээнд:

- 2.1. Үндэсний татварын албананд ажиллах иргэнд тавигдах шалгуурыг Татварын ерөнхий хууль, “Төрийн албаны тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Төсвийн тухай” “Нийтийн албананд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль болон байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Хураагч ажиллуулах журам”-ыг үндэслэн ойлгомжтой тодорхой болгон тогтооно.
- 2.2. Ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг албан тушаал бүрээр боловсруулж Татварын ерөнхий газрын дарга батална.
- 2.3. Үндэснийн татварын албаны газар, хэлтэс, төвийн дарга, татварын улсын /ахлах/ байцаагч нь тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан ерөнхий шалгуурыг бүрэн хангасан эдийн засагч, санхүүч, нягтлан бодогч, эрх зүйч мэргэжилтэй, бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн, төрийн албан хаагчийн тангараг өргөсөн, татварын улсын байцаагчийн эрх авсан Монгол Улсын иргэн байна. Ажлын шаардлагаар бусад нарийн мэргэжлийн иргэнийг татварын улсын байцаагчаар ажиллуулж болно.

Гурав. Үндэсний татварын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажиллах албан хаагчийг сонгох, томилох

Үндэсний татварын алба нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх ба хуульд заасан болзол журмын дагуу иргэдийг татварын албанд орох адил тэгш боломжоор хангах, мэргэшсэн тогтвортой төрийн үйлчилгээг бий болгож, хүний нөөцийн удирдлагаар хангах бодлогын хүрээнд:

- 3.1. Үндэсний татварын албанд томилогдох албан хаагчийг сонгох, хүний нөөцийг бүрдүүлэхэд “Төрийн албаны тухай”, Татварын ерөнхий хууль, УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам” болон Төрийн албаны зөвлөлөөс баталсан журам, заавар, зөвлөмжийг баримтална.
- 3.2. Төрийн захиргааны удирдах албан тушаалтан буюу татварын албадын газар, хэлтсийн даргын албан тушаалд ажиллуулахад дараах зарчмыг баримталж, Татварын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөл зохион байгуулна.
- 3.2.1. Үндэсний татварын албаны удирдах албан тушаалд томилогдох албан хаагчдын хувьд тухайн ажлын байрны тодорхойлолтын ерөнхий шаардлагыг бүрэн хангасан, багаар ажиллах чадвартай, ёс зүйн хэм хэмжээг баримталдаг албан хаагчдаас Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгж сонгон шалгаруулж Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.3. Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалд шинээр ажилтан авч ажиллуулахад дараах зарчмыг баримтална.
- 3.3.1. Татварын ерөнхий газрын дотоод бүтцийн болон харьяа нэгжид сул орон тоо гарсан тохиолдолд татварын алба, төрийн бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас нөхөх, хэрэв нөхөх боломжгүй бол уг албан тушаалд тавих онцлог шаардлага, шалгуурыг хангасан төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс нөхөх хүсэлтээ Төрийн албаны зөвлөлд хүргүүлнэ.
- 3.3.2. Төрийн албан хаагчийн төрийн албаны нөөцөд байгаа гадаадын их, дээд сургууль төгссөн, мэргэжил дээшлүүлсэн, магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цол хамгаалсан иргэдээс тэргүүн ээлжинд сонгон авч ажиллуулах зарчмыг баримтална.
- 3.3.3. Аймгийн татварын газар, хэлтэст сул орон тоо гарсан тохиолдолд татварын алба болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас нөхөх, хэрэв нөхөх боломжгүй бол уг албан тушаалд тавих онцлог шаардлага, шалгуурыг хангасан төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс нөхөх хүсэлтээ орон нутгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлнэ. Тухайн төрийн албаны салбар зөвлөлөөс шалгаруулалт хийж, нэр дэвшигчийг санал болгосноор аймгийн татварын /газар/ хэлтсээс ТЕГ-ын Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгжид уламжлан Татварын ерөнхий газрын даргын шийдвэрээр томилно.
- 3.4. Төрийн үйлчилгээний албан тушаалд шинээр ажилтан авч ажиллуулахад дараах зарчмыг баримтална.
- 3.4.1. Татварын ерөнхий газрын дотоод бүтцийн болон харьяа нэгжид төрийн үйлчилгээний гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд татварын албаны төрийн үйлчилгээний албан хаагчдаас нөхөх, эсвэл нөхөх боломжгүй бол уг албан тушаалд тавих онцлог шаардлага, шалгуурыг

хангасан иргэдээс харьяалах албаны Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгж ажилд орох хүсэлт гаргасан хүмүүсийн өргөдлийг судалж, дүгнэлт гарган холбогдох албаны даргын хүсэлтээр Татварын өрөнхий газрын даргын шийдвэрээр томилно.

- 3.4.2. Татварын өрөнхий газрын дотоод бүтцийн болон харьяа нэгжид төрийн үйлчилгээний туслах албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн албан тушаалд тавих онцлог шаардлага, шалгуурыг хангасан иргэдээс харьяалах албаны Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгж ажилд орох хүсэлт гаргасан хүмүүсийн өргөдлийг судалж, танилцуулан Татварын албаны даргын шийдвэрээр ажилд авч ажиллуулна.
- 3.5. Үндэсний татварын албаны төрийн захиргааны албан тушаалд анх орсон албан хаагчийг Төрийн албаны тухай болон Татварын өрөнхий хуулийн хүрээнд нэг жилийн туршилтын хугацаагаар томилно.

Дөрөв. Үндэсний татварын албаны албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх

Үндэсний татварын албаны онцлог бүхий, олон улсын стандартад нийцсэн, хөрвөх чадвартай боловсролыг эх орондоо олж авах, гадаадын их дээд сургуульд суралцуулах, Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт албан хаагчдыг хамруулах, мэргэжил дээшлүүлэх, эзэмшсэн мэдлэг, мэргэжлээрээ ажил, хөдөлмөр эрхлэх боломжтой байх нөхцөл бололцоогоор хангах бодлогын хүрээнд:

- 4.1. Үндэсний татварын албаны сургалтын бодлого, хөтөлбөрийн дагуу албан хаагчдыг сургаж мэргэшүүлнэ. Албан хаагчдын сургалт тасралтгүй системтэй байна.
- 4.2. "Татварын улсын байцаагчийн сургалтын хөтөлбөр"-ийн дагуу мэргэшүүлэх сургалт /анхан, дунд шат/, ахисан түвшний сургалт /гүнзгийрүүлсэн шат/, ажлын байран дахь болон онлайн сургалтаар татварын улсын /ахлах/ байцаагчдыг мэргэшүүлнэ.
- 4.3. Татварын улсын байцаагчдыг мэргэшүүлэх сургалтыг Татварын өрөнхий газрын Сургалтын асуудал хариуцсан нэгж тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хот, бүсийн сургалтын төвүүд болон шаардлагатай тохиолдолд аймгийн татварын газар, хэлтсийг түшиглэн зохион байгуулна.
- 4.4. Улсын болон хувийн зардлаар гадаад улсын их, дээд сургуульд элсэн суралцах, мэргэшлээ дээшлүүлэх албан хаагчдыг төрийн албаны нөөцөд бүртгэж, гэрээ байгуулна.

Тав. Үндэсний татварын албанд ажиллаж байгаа албан хаагчдыг
шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

Үндэсний татварын албаны ажиллах хүчиний газар зүйн болон мэргэжлийн онцлогтой холбоотой шилжилт хөдөлгөөний шаардлага, тусгай ажил мэргэжил, шаардах ажил албан тушаалд хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох бодлогын хүрээнд:

- 5.1. Татварын албыг мэргэшсэн, тогтвортой суурьшилтай ажиллах хүний нөөцөөр хангах үүднээс Татварын албанд ажиллаж байгаа албан хаагчдыг тухайн албан тушаалд 3-аас доошгүй жил ажиллуулна.

- 5.2. Татварын улсын байцаагчийг сэлгэх, шилжүүлэн ажиллуулахад тухайн албан хаагчийн шилжин ажиллах хүсэлт, шилжих шалтгаан, ажлын үр дүнг харгалзан шийдвэрлэнэ. Шилжих, сэлгэн ажиллуулах асуудлыг Татварын ерөнхий газрын Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгжтэй зөвшилцөн шийдвэрлэнэ.

Зургаа. Үндэсний татварын албанд ажиллаж байгаа албан хаагчийг
албан тушаал дэвшиүүлэх

Үндэсний татварын албаны төлөвлөлт, гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх, урамшуулах, зэрэг дэв олгох, ёс зүйн болон сахилга хариуцлагын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох бодлогын хүрээнд:

- 6.1. Албан хаагчдын амжилт, ирээдүйдээ итгэх итгэлийг бэхжүүлэх үүднээс ажлын үр дүнгээр албан хаагчдыг урамшуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах, тэдний цалин хөлс, нийгмийн баталгаа, орон байраар хангах, эрүүл мэндийг хамгаалах асуудлыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, хөтөлбөр, журмын дагуу шийдвэрлэнэ.
- 6.2. “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн тувшин, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам”-д заасны дагуу тухайн жилийн ажлын үр дүнгийн үнэлгээ, ажлын байрны тодорхойлолтод заасан үүргийн гүйцэтгэлийг харгалзан албан хаагчдыг шагнаж урамшуулах, албан тушаал дэвшиүүлэх, цол зэрэг дэв олгох, ахиулах, сургалтад хамруулах, сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 6.3. Албан тушаал дэвшиүүлэн ажиллуулахад дараах зарчмыг баримтална.
- 6.3.1. Мэргэжлээрээ 5-аас дээш жил, Татварын албанд 3-аас дээш жил ажилласан, ажлын дадлага туршлагатай байх.
- 6.3.2. Харилцааны соёл, ажлын зохион байгуулалт, баримт бичиг боловсруулах, санал бодлоо зөв илэрхийлэх чадвартай, аливаа асуудалд ноён нуруутай ханддаг, хүнтэй ажиллах ур чадвар, арга барилыг эзэмшсэн байх.
- 6.3.3. Удирдахуйн ухааны онол арга барилыг эзэмшсэн, бусдад нөлөөлөх, манлайлах, төрийн албан хаагчийн болон татварын албаны ёс зүйн хэм хэмжээг сахих, хариуцлага хүлээх чадвартай байх.
- 6.3.4. Шаардлагатай гадаад хэлний мэдлэгтэй, татварын болон хэрэглээний програмуудыг бүрэн эзэмшсэн байх.
- 6.3.5. Удирдах албан тушаалд нэр дэвшигч нь тухайн үед сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.